


## 13.2 Төгсөлт - Хичээлийн дүн баталгаажуулалт

### Сургалтын менежер хичээлийн дүн баталгаажуулалт



#### • Цахим журнал ашигладаг:

- Хичээл заадаг багш нь жилийн эцсийн дүнг системд бүртгэж баталгаажуулна.
- Ангийн багш нь хичээл заадаг багшийн цахим журнал дээр бүртгэсэн дүнг шууд татан авч ашиглана.

#### • Цахим журнал ашигладаггүй:

- Анги удирдсан багш нь суралцагч бүрийн жилийн эцсийн дүнг бүртгэнэ.

Төгсөлтийн бүртгэлийн “Хичээлийн дүн” хэсэгт баталгаажуулалт хийнэ.

Уг төгсөлтийн бүртгэлийн “Хичээлийн дүн”- гийн баталгаажилт нь

Бага боловсрол ----- 5-р ангийн дүнг

Суурь боловсрол -----9-р ангийн дүнг

Бүрэн дунд боловсрол-----12-р ангийн дүнг баталжуулалт хийнэ.

Сургалтын менежер зөвхөн “Хянагдаж байгаа” төлөвтэй дүнг хянаж, баталгаажуулж, цуцлах боломжтой.

Аль анги, бүлгийн хичээлийн дүнг хянах гэж байгааг “Хөтөлбөр” “Анги” “Бүлэг” сонгож “Баталгаажилт” ийг дарснаар баталгаажуулах үйлдэл хийх цонх гарч ирнэ.

1. Хичээлийн дүн дарж сонгоно.
2. Аль анги бүлгийн баталгаажилт хийх гэж байгааг сонгоно.
3. Хичээл баталгаажуулалтын үйлдэл хийх цонх руу шилжнэ.

Дэвшилт

Хурал

Хянах самбар

Заавар

**Хичээлийн дүн 873/900**

Шалгалт 0/90

Дүүргэлтийн бүртгэл 0/30

Дэвшилтийн бүртгэл 0/30

Дэвшилтийн нэгтгэл 0/30

Хөтөлбөр Бүрэн дунд боловсролын өдрийн хөтөлбөр /Ердийн/ Анги 11-р анги Бүлэг 11-а

453+491+491 /11-р анги/ төл

Хичээлийн дүн оруулах

1 Дүнгийн нэгтгэл /хичээлээр/ 2 Дүнгийн нэгтгэл /Суралцагчаар/ 3 Дүнгийн нэгтгэл /Суралцагч :Хичээл /

Өмнөх жилийн дүн 11-р анги

Хичээл	Төрөл	Нийт судалсан	Дүн батлагдсан	Дүн бүртгэсэн	Хянагдаж байгаа	Дүн цуцлагдсан
1 Англи хэл 11 (АНГ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
2 Биеийн тамир 11 (БНТ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
3 Биологи 11 (БИО 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
4 Газарзүй 11 (ГЗЗ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
5 Дизайн/зураг зүй, технологи 11 (ДЗЗ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
6 Иргэний өс зүйн боловсрол 11 (ИБЛ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
7 Математик 11 (МАТ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
8 Монгол хэл 11 (МХЛ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
9 Монголын түүх 11 (МТХ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0
10 Мэдээллийн технологи 11 (МТИ 11101) Заавал	Заавал	30	30	0	0	0

4. Тухайн бүлгийн аль ангийн ямар төрлийн хичээлийн дүнг батлах гэж байгааг сонгоно.

5. Аль хичээл гэдгийг сонгоно. Хөтөлбөрийн дагуу заавал хичээл бол заавал төрөлтэй хичээл дотор байгаа. Сонгон хичээл бол сонгон судлах хичээлийг сонгоно.

-Гүнзгий хичээл бол сонгох судлах төрлийг сонгоно.

6. Бүх суралцагчийг сонгох боломжтой. Зөвхөн нэг суралцагчийн хичээлийн дүнг баталгаажуулах бол тухайн суралцагчийн нэрийн урд талыг сонгож баталгаажуулна.